



АТАР-ӨРГӨӨ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 14 өдөр

№ 05

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3, 60.4, 67 дугаар зүйлийн 67.1, Компанийн дүрмийн 7.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол, Төлөөлөн удирдах Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт компанийн байр (Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-20, Атар-Өргөө ХК-ийн байрны хурлын танхим)-д хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
 - Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 - Компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах.
 - 2021 онд ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах.
 - Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын даргад:	Б.Мөнхдалай	ТУЗ-ийн дарга
Гишүүн	С. Баярмаа	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
4. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст даалгах нь:
 - Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зар мэдээг 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл (өдөр тутмын сонин, телевиз) болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгсэлээр хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх.
 - Энэхүү мэдээллийг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх.
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай мэдэгдлийг холбогдох бичиг баримтын хамт Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор хүргүүлэх.
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тэдгээрийн танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төсөл, санал авах хуудсыг үнэт цаасны брокер, диллерийн

- компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор хүргүүлэх.
- Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс мөн оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, саналын хуудсаар санал авах.
- 5 Хурал зарласан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд дор дурдсан баримт бичгийг танилцуулахыг хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст зөвшөөрсүгэй. Үүнд:
- Компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайлан.
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудиторын дүгнэлт.
 - Ногдол ашиг тараахгүй байх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
 - Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга.
 - Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичиг нарын цалин, урамшуулал, зардлын товчоо
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд холбогдох бусад мэдээлэл.
 - Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад мэдээлэл.
- 6 Ээлжит хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
- 7 Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөр тогтоосугай.
- 8 Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 17.00 цагаар тогтоосугай.
- 9 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Мөнхдалайг сонгосугай.
- 10 Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 01 дүгээр шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар Ц.Энхтувшин, гишүүнээр Θ.Оюун-эрдэнэ, Ц.Мөнхцэцэг нарыг томилсугай.

УЛАНБААТАР ХОТ
АТЛАР-ӨРГӨӨ
ХУРЛЫН ДАРГА

Б.МОНХДАЛАЙ



АТАР-ӨРГӨӨ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ 03 САРЫН 19-НЫ ӨДРИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Атар-Өргөө ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 10:00 цагт компанийн хурлын танхимд хуралдав.

Энэ удаагийн хуралд Атар-Өргөө ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгогдсон Б.Мөнхдалай, Б.Ганбат, Ж.Сайнбилэг, Г.Энхболд, М.Мөнхтэнгис, Г.Баттулга хараат бус гишүүнээр сонгогдсон С.Бямбаахорлоо, Т.Жигмэддагва, П.Болормаа нар оролцож, хурлын ирцийг 100 хувь бурдуулэв. Хурлыг ТУЗ-ын дарга Б.Мөнхдалай даргалав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД:

1. Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг тогтоох,
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлууд
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг батлах
4. Хуралд бэлтгэх, зохион байгуулахтай холбоотой зарим асуудлуудыг хэлэлцэн батлах
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ээлжит хурлын дарга, зохион байгуулах комиссын дарга, гишүүд тооллогын комиссын дарга, гишүүднийг томилох тухай

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Б.Мөнхдалай: Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудал бол компаний 2022 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаа хэзээ хийх, энэ хурлаар хэлэлцэх асуудлууд, мөн хурлыг зохион байгуулахтай холбоотой зүйлүүдийг батлах зэрэг байгаа болно. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Б.Ганбат: Хувьцаа эзэмшигчдийн хурлаа жил болгоны уламжлал ёсоор 4 сарын сүүлээр хийсэн нь зөв болов уу. Хууль журмынхаа дагуу 3 сарын 21, 22-нд зараа тавиад 4 сарын 29-ний хооронд ажлын өдрөөр хурлаа товlöö.

Ж. Сайнбилэг: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар жил бүр тайлагнадаг жилийн эцсийн тайлан баланс, 2022 оны төлөвлөгөөнүүд маань бэлэн болсон тул татгалзах зүйлгүй байна.

С.Бямбаахорлоо: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар уламжлал ёсоороо жилийн эцсийн тайлан баланс, түүний аудитын дүгнэлт, 2022 оны төлөвлөгөө, мөн ТУЗ-ийн гишүүд, тэдгээрийн цалин зардлууд, мөн ногдол ашиг тараахгүй болсон шийдвэрүүдээ танилцуульяа.

Г. Энхболд: Зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ын дарга Б. Мөнхдалайг томилж, тооллогын комиссын гишүүдээр шинээр томилоё.

Хуралд оролцсон бусад гишүүд татгалзсан, түтгэлзсэн санал гаргаагүй тул 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг дараах шийдвэртэйгээр зохион байгуулахаар 100 хувийн саналаар дэмжив.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 09:00 цагт компанийн байранд хуралдуулахаар тогтов.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:
 - Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлуулах
 - Компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах.
 - 2021 онд ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах.
 - Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулав
Комиссын даргад: Б.Мөнхдалай ТУЗ-ийн дарга
Гишүүн С.Баярмаа ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
4. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст дараах зүйлсийг даалгав:
 - a. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зар мэдээг 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл (өдөр тутмын сонин, телевиз) болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгсэлээр хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, үүнтэй холбоотой мэдээ мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, арилжаа эрхлэх байгууллагуудад холбогдох хууль журмын дагуу хугацаанд нь хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичиг С. Баярмаа –д даалгав.
 - b. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс мөн оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, саналын хуудсаар санал авах.
5. Хурал зарласан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд дор дурдсан баримт бичгийг танилцуулахыг хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст зөвшөөрөв: Үүнд
 - Компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайлан.
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудиторын дүгнэлт.
 - Ногдол ашиг тараахгүй байх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
 - Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга.


- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичиг нарын цалин, урамшуулал, зардлын товчоо
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд холбогдох бусад мэдээлэл.
- Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад мэдээлэл.
- 6. Ээлжит хурлын “Санал авах хуудас”-ны загварыг хавсралтаар батлав.
- 7. Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 04 дүгээр сарын 12 -ний өдрөөр тогтов.
- 8. Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 17.00 цагаар тогтов.
- 9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Мөнхдалайг сонгов.
- 10. Тооллогын комиссын даргаар Ц.Энхтувшин, гишүүнээр Ө.Оюун-эрдэнэ, Ц.Мөнхцэцэг нарыг томилов.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



S. БАЯРМАА

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА




Б.МӨНХДАЛАЙ

ГИШҮҮН




Б.ГАНБАТ




Ж.САЙНБИЛЭГ



Г.ЭНХБОЛД



М.МӨНХТЭНГИС



Г.БАТТУЛГА



Т.ЖИГМЭНДАГВА



С.БЯМБАХОРЛОО



П.БОЛОРМАА